



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙХАН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/47

Онги

Эм эргэлтийн сангийн удирдах
болон хяналтын зөвлөл байгуулах тухай

Эрүүл мэндийн сайдын 2011 оны 297 дугаар тушаал, Аймгийн Засаг даргын 2011 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/630 дугаар захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эм эргэлтийн сангийн удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Дарга: Засаг дарга

Нарийн бичгийн дарга: Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Гишүүд: Эрүүл мэндийн төвийн дарга

Эм эргэлтийн сангийн эрхлэгч

Эрүүл мэндийн төвийн нягтлан бодогч

Иргэний төлөөлөл : (Д.Алтанцэцэг)

Иргэний төлөөлөл : (Д.Одончимэг)

2. Эм эргэлтийн сангийн хяналтын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Ц.Алтангэрэл (Засаг даргын орлогч)

Нийгмийн даатгалын байцаагч

Иргэний төлөөлөл: (Ш.Оюунчимэг)

3. Сум, багийн зайлшгүй шаардлагатай эмийн хангамжийг тогтвортой байлгах зорилгоор эм эргэлтийн санг удирдлага арга зүйгээр ханган ажиллахыг удирдах зөвлөлийн даргад, Эм эргэлтийн сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг улирал бүрийн сүүлийн 20-ны дотор удирдах зөвлөлд тайлагнаж байхыг Эм эргэлтийн сангийн эрхлэгч, нягтлан бодогч нарт даалгасугай.

4. Сумын Эрүүл мэндийн төв болон ард иргэдэд худалдаалж байгаа эмийн үнэ, эм эргэлтийн сангийн үйл ажиллагаа, санхүүгийн тайланд хяналт тавин ажиллахыг хяналтын зөвлөлийн дарга (Ц.Алтангэрэл)-д үүрэг болгосугай.

5. Энэ захирамж гарсантай холбогдуулан 2021 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн А/71 дугаартай захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЛУВСАНРАГВА